САЛБАРЫН ХӨГЖИЛ, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ИННОВАЦ, ТЕХНОЛОГИ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ДАРХИЖАВ ОВОГТОЙ БОЛОРМААГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД”** | | | | | | | |
| 2. | **Арга хэмжээ 1.1.7.** Салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, судалгаа, төслийн санал боловсруулах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана. | - Саналын тоо, | Холбогдох газарт 3 санал хүргүүлсэн. Санал болгосон арга хэмжээний тоо - 13 | Салбарт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох, судалгаа хийж, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох байгууллагууд ад 2-оос доошгүй төслийн санал хүргүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Япон Улсын Засгийн газраас Монгол Улсад олгох буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгждэг “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-өөр 2027 оны санхүүгийн жилд Монгол Улсад хэрэгжүүлэх саналд тусгуулахаар дараах төслийн саналыг 2025.01.21-ний өдрийн 03/224 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:<br>1.Гэр хорооллын хэсэгчилсэн инженерийн хангамжийн эх үүсвэрт байглийн нөөцийг ашиглах төсөл;<br>2.Дулааны цахилгаан станцаас гарах хаягдал /үнс, шаарга/-ыг боловсруулан барилгын материалын түүхий эд болгон ашиглах /технологи, орц, норм/ судалгаа;<br>3.Нар, салхины эх үүсвэр ашиглан гэр хорооллын өрхийг дулаанаар хангах төсөл;<br>4.Ногоон барилгын материалыг тодорхойлох, зардал, үр өгөөжийн тооцооллын судалгаа;<br>5.Боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалт;<br>Мөн салбарын хөгжилд нэн шаардлагатай 12 тоног төхөөрөмжийн саналыг загварын дагуу гарган хавсралтаар хүргүүлсэн. | 2024.01.02-2024.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Арга хэмжээ 1.1.9.** Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь, нэмрийн хэрэгжилтийг хангана. **ЗГҮАХХҮТ /2024-2028/** | -Тайлан<br>-Арга хэмжээний санал | ЗГХЭГ-т хүргүүлсэн Олон улсын Парисын хэлэлцээрт салбарын чиглэлээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан 1. | Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь, нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус яамны хариуцах чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, ҮТХН-ийн зорилтыг шинэчлэх хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж, салбарын тайланг хүргүүлсэн байна. | 1.Монгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн 2 жил тутмын ил тод байдлын 1, 2-р тайлан, Үндэсний 4-р тайлан илтгэлд тусгах салбарын тайланг Уур амьсгалын өөрчлөлтийн хамтын ажиллагааны төвийн ccrccmongolia@gmail.com цахим хаягаар 2025.01.22-ны өдөр илгээсэн.<br>2.“Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд утааны асуудлаарх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүн, шийдэл” сэдвээр 2025 оны 02 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ерөнхий хяналтын сонсголд сайдын тавих илтгэл, салбарын 2018-2024 онуудад хийгдсэн ажил, арга хэмжээний танилцуулга, холбогдох мэдээллийг бэлтгэж Ж.Чинбүрэн УИХ-ын гишүүнд /УИХ-ын тамгын газарт/ 01/232 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>3.Монгол Улсын ҮТХН 3.0 (NDC 3.0)-ийн зорилтыг ахиулан тодорхойлох үүрэг бүхий Үндсэн ажлын хэсэг болон Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг БОУАӨ-ийн сайдын 2024.11.22-ны өдрийн А/807 тоот тушаалаар байгуулсан бөгөөд Анхны хурлыг 2025.02.04-ны өдөр Туушин зочид буудалд зохион байгуулахад Барилгын салбарын дэд ажлын хэсгийн гишүүд оролцсон. Ажлын хэсгийн гишүүдтэй ХББОСЯ-ны хурлын танхимд 2025.02.05-ны өдөр салбар хуралдааныг зохион байгуулж, барилгын салбарын зорилтыг хэрхэн ахиулах, шинэ зорилтыг тодорхойлох талаар санал солилцож, уулзалт хийлээ. Энэ ажлын хүрээнд барилгын салбарын хариуцсан зөвлөхтэй хамтран салбарын дэд ажлын хэсгийн замын зураглал боловсруулах, зорилтыг шинэчлэх болон ахиулах талаарх ажлын уулзалтуудын агуулгыг боловсруулан 5 удаагийн хурлыг зохион байгуулж, барилгын салбарын шинэчилсэн арга хэмжээний саналыг боловсруулан Үндсэн ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 4.Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг МУ-ын Шадар сайд бөгөөд ЭЗХ-ийн сайд болон БОУАӨ-ийн сайд нарын хамтарсан А/32/09 тушаалаар 2025.01.21-ний өдөр байгуулсан. Ажлын хэсгийн анхны хурал 2025.02.11 хуралдаж, хуулийн төслийг хэлэлцэн боловсруулсан. Салбарын уялдааг ханган оролцсон. | | |
| 4 | **Арга хэмжээ 1.1.10:** Барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувь | 2024 онд БХБЯ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 39 арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн. Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн биелэлт 100% | “Барилга, хот байгуулалтын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд чиглэсэн 20-оос доошгүй арга хэмжээг яамны нэгжүүдийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан, хэрэгжилтийг хангуулсан байна. | “Салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхэд чиглэсэн 22 арга хэмжээг яамны нэгжүүдийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулсан.<br>“Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”-ыг холбогдох журмын дагуу хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч ажиллаж байна. Үүнд:<br>– Ногоон барилгын эксперт, аудитор бэлтгэх урьдчилсан сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Барилгын хөгжлийн төв дээр салбарын мэргэжлитнүүдийн дунд зохион байгуулсан;<br>– Амины орон сууцны мэдээллийн төвөөс Жижиг, дунд үйлдвэрлэгч, барилгын бригадуудад зориулан зохион байгуулсан “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны чадавхижуулах сургалт” 2025 оны 03 дугаар сарын 20, 21, 22-ны өдөр “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BESTGER) гэрчилгээ олгох журам" болон “Барилгын материалын үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, баримталж буй бодлого, тогтвортой, ногоон үйлдвэрлэл, бүтээгдэхүүн” сэдвээр мэдээлэл өгч оролцсон;<br>– “Ногоон барилгын хүрээлэн” ТББ-аас Дархан, Эрдэнэт, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймгийн Газрын харилцаа, | 2025.01.02-2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | барилга, хот байгуулалтын газрын инженер, техникийн ажилчид болон ААНБ-дад “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”, “Ногоон барилгын (BESTGER) гэрчилгээ олгох журам"-ийн талаар мэдлэг, мэдээлэл олгох сургалт зохион байгуулсан;<br>– Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 74 дүгээр тушаалаар Ногоон барилгын үзэл баримтлал, ногоон барилгын талаарх мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор “Ногоон барилгын үнэлгээ (Bestger)-ний аргачлал”, “Ногоон барилгын (Bestger) гэрчилгээ олгох журам”-ыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.<br>Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 114 дүгээр тушаалаар “Ногоон барилгын аудитор, сургагч багш бэлтгэх журам” баталсан.<br><br>“Ногоон барилгын аудитор бэлтгэх сургалт”-ыг 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 27-ны өдрийн хооронд зохион байгуулсан бөгөөд сургалтанд нийт 53 ИТА хамрагдсан. 2025 оны 06 дугаар сарын 09-ны өдөр шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулж _ аудитор гэрчилгээ авсан.<br>Сөүлийн Үндэсний Их Сургуулиас хэрэгжүүлж буй S-Quad төслийн хүрээнд байгальд ээлтэй, ногоон барилгын үнэлгээ, гэрчилгээжүүлэх, бодлогын баримт бичигт тусгах талаар БНСУ-ын туршлагад үндэслэн Солонгос улсын Бүтээмжийн төвийн чанарын баталгаажуулалтын газрын захирал, албан хаагч нар 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр яамны Хурлын танхимд мэдээлэл хийж, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | яамны болон харьяа байгууллага, төрийн бус байгууллага, зураг төсөл зохиогч аж ахуйн нэгж, их сургуулийн судлаач нар оролцсон. | | |
| 5 | **Арга хэмжээ 1.1.11.** Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох, цахим системийн үйл ажиллагааны чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна.<br>**ЗГҮАХХҮТ /2024-2028/** | Сургалтын хөтөлбөр 1 | Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох цахим системд хөгжүүлэлт хийгдсэн. | Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, хөтлөх, бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтын хөтөлбөр боловсруулж, салбарын мэргэжилтнүүдийг чадавхжуулсан байна. | Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн /Climate Promise-2 / Уур амьсгалын амлалт-2 төслийн хүрээнд Барилгын салбарын хүлэмжийн хийн тооллогын цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, хөтлөх, бүрдүүлэх чиглэлээр зохион байгуулах сургалтын хөтөлбөрийн агуулга, ямар асуудлыг тусгах, юу дутагдалтай байгаа болон хэн танилцуулга, мэдээлэл хийх талаар урьдчилсан уулзалтыг тус төслийн зохицуулагч Д.Саруул, сургалт хариуцсан Ундармаа нартай 2025.05.28-ны өдөр хийж, санал солилцсон.<br>Хугацаа болоогүй<br><br>Барилгын хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг тоолох цахим системийн 2024 оны жилийн эцсийн тайланг БХТ-ийн 2025.03.19-ний өдрийн 01/338 тоот албан бичгээр ирүүлсэн. Цахим систем хариуцсан албан тушаалтантай болсноор үйл ажиллагаа тогтвортой болж, тайлан мэдээг хугацаанд нь гаргадаг болсон.<br>ХХЯ-ыг 2023 болон 2024 онтой харьцуулан үзэхэд ХУД-ийн ялгаруулалт 1,6%-иар өссөн бол, БЗД 1,6%-иар буурсан, БГД 2,4%-иар буурсан, СБД 3,1%-иар өссөн, СХД 1,3% буурсан, ЧД 0,7% өссөн үзүүлэлттэй байна. ХХЯ нь тухайн дүүргийн хүн амын тоо, орон сууц, олон нийтийн барилгын тооноос хамаарч ялгаатай тооцоологдож байна. | 2025.01.02-2025.06.15 | 100% |
| 6 | **Арга хэмжээ1.1.12**: Хүлэмжийн хийн ялгарал багатай, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, материал үйлдвэрлэлийн чиглэлээр салбарын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | -Хамтран ажиллаж дэмжлэг үзүүлсэн төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын | СХД-ийн Амины орон сууцны мэдээллийн төвийн нээлтийг 2024 оны 12 дугаар сард хийсэн. | Салбарын аж ахуйн нэгж байгууллагатай хүлэмжийн хийн ялгарал багатай, эрчим хүчний хэмнэлттэй | 1.Эрчим хүчний хэмнэлттэй, хөрс, агаар орчны бохирдолгүй ногоон барилгын шаардлагад нийцсэн барилгын дэвшилтэт технологийн шийдлүүдийг нэг дороос сонгох боломжийг бүрдүүлсэн "Амины орон сууцны мэдээллийн төв"ийг байгуулах тендерийг нээлттэй зарласан. Тендерт шалгарсан “Амины орон сууны инновац, | 2025.01.02-2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоо<br>-Амины орон сууцны мэдээлэл дамжуулах төвийн тоо | | барилга барьсан, материал үйлдвэрлэсэн, импортолсон болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулж, амины орон сууцны мэдээлэл дамжуулах төвийг дүүргүүдэд байгуулсан байна. | хөгжлийн төв"-тэй 3 байршилд буюу ЧД, СХД, БЗД-ийн төвүүдийг байгуулах, үйл ажиллагааг хангахаар тус яамтай гэрээ байгуулан ажиллаж байна.<br>"Амины орон сууцны мэдээллийн төв"-үүд нь СХД-ийнх 2024.12.18, БЗД-ийн төв нь 2025.02.10, ЧД-ийн төв нь 2025.04.28-ны өдөр нээлтээ хийсэн. Тус төвүүдэд барилгын салбарт ногоон технологи нутагшуулагч 80 гаруй байгууллагын үзүүлэнгийн хэсэг, оффис байрлан ажиллаж байна. Эдгээр төвүүд нь нээлтээ хийсэн өдрөөс хойш давхардсан тоогоор 5000 гаруй иргэдэд мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна.<br>Орон нутгаас буюу Өмнөговь, Хөвсгөл, Ховд, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Дорноговь зэрэг аймгуудаас иргэд зорин ирж амины орон сууцны мэдээллийн төвөөс ногоон амины орон сууцны талаар мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх, банкуудын ногоон зээлд хэрхэн хамрагдах талаар судлах зэрэг мэдээллүүдийг сонирхож, туршлага судласан.<br>Иргэдэд зориулсан эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зөвлөгөө, мэдээллийн нээлттэй өдөрлөгийг 2025.01.18, 2025.03.17-19, 2025.03.05, 2025.04.04, 2025.05.15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус нээлттэй өдөрлөгүүдийн үеэр иргэд илүү идэвхитэй оролцож мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл авч дэвшилтэт технологийн шийдлүүдтэй танилцдаг давуу талтай бөгөөд өдөрлөгийн үеэр аж ахуйн нэгжүүд бүтээгдэхүүн үйлчилгээн дээрээ 20-30 хувийн хямдрал урамшуулал үзүүлж, урьдчилсан захиалгууд авсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Иргэдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн инженер, эксперт, дэвшилтэт технологийн шийдэл нэвтрүүлэгч нарын мэргэжлийн зөвлөгөө, мэдээллийг богино видео хэлбэрээр бэлтгэн цувралаар хүргэж байна. Үүнд:<br>• Дотор агаарын чанар буюу амьсгалдаг барилга<br>• Нар нэхэмжлэх илгээхгүй - Сэргээгдэх эрчим хүч гэж юу вэ?<br>• Эрчим хүчний хэмнэлттэй дулаан нөөцлүүрт халаагуур<br><br>Тус төв дээр ирж зөвлөгөө, мэдээлэл авсан нийт иргэдийн 80% нь банкны зээлээр барих сонирхолтой бөгөөд тэдгээрийн 15% нь 60мкв доош, 45% нь 60-80мкв, 30% нь 80-100мкв, 10% нь 100мкв дээш талбай бүхий амины орон сууц барих хүсэлтэй гэсэн судалгаа гарч байна.<br>2.Засгийн газрын “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2025 оны 133 дугаар тогтоолыг хэрэгжилтийг хангах хүрээнд Эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг иргэдэд сурталчлан танилцуулах, оролцогч байгууллагуудын уялдааг хангах зорилгоор “Дулаан байшин” Амины орон сууцны өдөрлөгийг БОУАӨЯ, ЭХЯ, НЗДТГ-тай хамтран Сүхбаатарын талбай дээр 2025.05.05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгт 82 бүүт ажиллуулж, үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч ААН байгууллагуудыг байрлуулж, хэсэг болгосон. Тус өдөрлөгт салбарын төрийн бус байгууллага, аж ахуй нэгж | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл, банк санхүүгийн салбарын нийт 91 байгууллагын төлөөлөл оролцож нийт 10,000 орчим, давхардсан тоогоор 29,562 иргэнд эрчим хүчний хэмнэлттэй, дулаан алдагдалгүй, тэсвэртэй, ногоон амины орон сууц барих, нөхцөл сайжруулах, дулаалах дэвшилтэт технологийн шийдлүүдийг танилцуулсан.<br>Б хэсгийг хариуцан ажилласан бөгөөд ний 27 байгууллагын 28 бүүт байрласан. Оролцогч байгууллагуудыг нэгдсэн мэдээллээр хангах, зохион байгуулалтыг хийх, лого, танилцуулга, илтгэлгэлийг цуглуулан хэсгийн танилцуулгын хуваарийг гаргаж оролцогсдод хүргүүлсэн.<br>Өдөрлөгийн үеэр тараах сонингийн эх бэлтгэл, хэвлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулсан. Сонинг нийт 12 000ш хэвлүүлсэн.<br>Оролцогч байгууллагууд нь 241 ажил үйлчилгээ үзүүлэх, худалдах гэрээ; 187 бараа, бүтээгдэхүүний худалдаа хийсэн байна.<br>Хэсгүүдэд байрлах мэдээллийн хэсэгт нийт 31 илтгэл, өдөрт дунджаар 2 удаагийн давтамжтай танилцуулагдлаа.<br>Нэгдсэн мэдээллийн дэлгэцээр нийт 75 аж ахуй нэгж байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга шторк өдөрт дунджаар 3 удаагийн давтамжтай танилцуулагдлаа.<br>Өдөрлөгт оролцогч аж ахуй нэгж байгууллагуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаанд нийт оролцогсдын 75.8% буюу 69 аж ахуй нэгж байгууллага хамрагдсан. | | |
| **Зорилт 2. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ"** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 3.1:** Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан | - саналын тоо,<br>оролцсон | | | Дээд шатны байгууллага, бусад яамд, холбогдох газруудаас санаачлан батлуулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт | 2025.01.02-2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулсан хууль тогтоомж, бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд санал өгч, салбар хоорондын зохицуулалтыг хангаж ажиллана. | арга хэмжээний тоо | | | бичгүүдийн манай салбарын чиг үүрэгт хамаарах асуудал, арга хэмжээний биелэлтийг хугацаанд нь гарган хүргүүлэв.<br>Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт "/БОУАӨЯ-нд 2025-04-<br><br>онгол Улсын Уур амьсгалын өөрчлөлтийн 2 жил тутмын ил тод байдлын 1, 2-р тайлан, Үндэсний 4-р тайлан илтгэлд тусгах салбарын тайланг Уур амьсгалын өөрчлөлтийн хамтын ажиллагааны төвийн ccrccmongolia@gmail.com цахим хаягаар 2025.01.22-ны өдөр илгээсэн.<br><br>Бусад яамд, газраас боловсруулсан Улсын Их хурлын болон Засгийн газрын тогтоолын төслүүдэд албан бичгээр хариу хүргүүлсэн. Үүнд:<br>Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" /ЗГХЭГ-нд 2025- | | |
| 2. | **Арга хэмжээ 3.2:** Хариуцсан асуудлаар дээд шатны байгууллага, удирдлага, холбогдох байгууллага, иргэдийг бодит мэдээ, мэдээллээр хангаж ажиллана. | -тоо | | | Тус яамны Ёс зүйн дэд хороонд ЗГХХГ-ын 2025.02.27-ны өдрийн 04/274 тоот бичгээр ирүүлсэн гомдлын дагуу тус яамны СХГ-ын албан хаагчдад гаргасан өргөдөлд дүгнэлт гарган 2025.04.02-н өдрийн 13/1114 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |
| 3. | **Арга хэмжээ 3.3:** Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд сахих, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | Ёс зүй, ашиг сонирхлын зөрчлийн тоо | | | өтлөх нэрийн жагсаалтын дагуу газар, нэгжийн албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг архивын нэгж болгон хүлээлгэн өгсөн.<br>өрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/32 тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны материал, тендерийн баримт бичиг, холбогдох материалыг архивын нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгсөн.<br>лсын хөгжлийн жилийн төлөвлөгөө 2025-ын ажлын хэсгийн холбогдох материалыг архивын нэгж үүсгэсэн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | **Арга хэмжээ 3.4:** Хариуцсан асуудалтай холбоотой ирүүлсэн албан бичиг төлөвлөж явуулах, ирсэн бичигт хариу төлөвлөх, хүргүүлэх | Албан бичиг, өргөдөл, гомдол тоо | | | Эхний хагас жилийн байдлаар Хариуцсан асуудалтай холбоотой 35 албан бичиг ирсэн байна. Мөн 27 албан бичгийг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн боловсруулж холбогдох байгууллага, иргэнд хүргүүлсэн байна. | 2025.01.02-2025.06.15 | 100% |

## Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | “Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллах. | Санал | ХББОСЯ-ны ТНбД-ын 2024.09.24-ний өдрийн А/15 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдсан. | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна. | Монгол Улсын Их хурлын 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар батлуулсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан яамны хариуцах 7 зорилго 46 зорилтын 71 арга хэмжээг гарган, хариуцах нэгж бүрээс санал авч, төслийг бэлтгэсэн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |
| 2 | “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах | Хурал, Дүгнэлт, зөвлөмж | ХББОСЯ-ны ТНбД-ын 2025.02.15-ны өдрийн А/12 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. | | Салбарын нөхцөл байдлын шинжилгээг хариуцан боловсруулж, газруудаас хэрэгжилт, бодлогын баримт бичгүүдэд хийхээр тусгасан арга хэмжээ, төслүүдийн саналыг тусган 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн боловсруулсан. ЭЗХЯ-руу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/159 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |
| 3 | Баянхонгор аймгийн Өлзийт сумын “Сумын төвийн инженерийн шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил”-ын тендер шалгаруулалтын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах Үнэлгээний | | ХББОСЯ-ны ТНбД-ын 2025.02.15-ны өдрийн А/12 дугаар | | Энэхүү ажлын тендерийн баримт бичгийг 2025.02.27-ны өдөр батлуулж, тендерийг 28-ны өдөр нээлттэй зарласан. 2025.03.26-ны өдөр тендерийг нээсэн. Оролцогчийг үнэлсэн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хорооны нарийн бичгийн даргаар ажиллах | | тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. | | Баянхонгор аймгийн Өлзийт сумын “Сумын төвийн инженерийн шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил”-ын тендер шалгаруулалтын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад Эрингүрэн ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг 2025.04.07-ны өдрийн 03/1190 тоот албан бичгээр хүргүүлсэн. гэрээ байгуулагдсан. | | |
| 4 | Татварын хөнгөлөлт эдлэх "Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарт хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага"-ыг боловсруулах | | ХББОСЯ-ны ТНбД-ын 2024.11.13-ны өдрийн А/32 дугаар тушаалаар Ажлын хэсгийн Дэд ахлагчаар томилогдсон. | | ААНОАТ тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан Эрчим хүчний хэмнэлттэй, агаар, ус, хөрсний бохирдлыг бууурах ногоон барилгын үнэлгээг хангасан барилга байгууламжийг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй, хэмнэлттэй ногоон үзэл санаа, хандлага, дадлыг нэвтрүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулал үзүүлэх зорилгоор "Хот байгуулалт, барилга, нийтийн аж ахуйн салбарт хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага"-ыг Сайдын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 105 дугаар тушаалаар батлуулж, Захиргааны хэм хэмжээний актад 7268 дугаартай бүртгүүлсэн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |

## Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | **Арга хэмжээ 1.** Төрийн албаны тухай хууль, салбарын бусад хууль тогтоомж, тэдгээрийг дагалдан гарсан дүрэм, журмыг судлах, мэргэшүүлэх болон чадавхжуулах сургалтад хамрагдсан байна. | Сургалт, тоо | | | үрэв гараг бүрт ТАЗ болон Удирдлагын академиас хамтран зохион байгуулагдсан сургалтад мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор тасралтгүй хамрагдахыг зорьж оролцдог.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль,/2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр/<br>Ёс зүйн дэд хорооны ажиллах журам" /2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр баталсан./ | 2025.01.02-2025.06.15 | 100% |
| 2. | **Арга хэмжээ 2.** Хариуцсан асуудлын хүрээнд урт, богино хугацааны сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. | Сургалт, тоо | | | Дараах сургалт, семинарт оролцсон. Үүнд:<br>- “Монголын Улсын Үндэсний тодорхойлсон хувь нэмэрт жендэрийн эрх тэгш байдлыг тусгах нь сургалт семинар”-т .<br>- Удирдлагын академиас зохион байгуулсан **“Төрийн захиргааны байгууллагын стратеги төлөвлөлт”** сэдэвт богино хугацааны сургалтад 2025.02.17, 19-ны өдрүүдэд амжилттай хамрагдсан.<br>- “Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын хотжилтын тогтвортой байдлыг хангах, | 2025.01.02-2025.06.15 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл"-ийн хүрээнд чадавхжуулах сургалт-семинарт 2025.05.18-мэргэжил дээшлүүлсэн. /БНСУ/ | | |
| 3. | **Арга хэмжээ 3**. Үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж ЗГ, УИХ-ын тогтоол, хуулийн шийдвэртэй цаг тухайд нь танилцсан байна. | Сургалт, тоо | | | Шинээр батлагдан гарсан, салбарын үйл ажиллагаанд шууд болон шууд бус байдлаар ашигладаг хууль тогтоомж, УИХ, ЗГ-ийн шийдвэр, сайдын тушаалаар батлагдсан дүрэм, журамтай танилцсан.<br>Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор Глобал удирдагч Их сургуулийн Эрх зүйн магистрын хөтөлбөрт 2023-2025 онуудад хамрагдан суралцаж, амжилттай төгссөн. | 2025.01.02-2025.06.15 | 100% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

Ахлах шинжээч Д.Болормаа ............................ 2025.06.12 ..................

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)